мэдээний санд үнэлгээ хийнэ.				өдрийн ДЗХ-д танилцуулсан. Үнэлгээний үр дүнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд: - Эрүүл мэндийн сайдын 2023 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн А/197 дугаар тушаалаар зайлшгүй шаардлагатай эмийн Х дугаар жагсаалт, хүүхдийн ЗШЭ-ийн III дугаар жагсаалт тус тус шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор Лайсмед программд 374 нэрийн эмийн мэдээллийг нэмж оруулсан. - АТС кодын мэдээлэл дутуу 2543 нэрийн эмийн АТС кодыг шалгаж оруулсан. - 2011-2021 онд улсын бүртгэлд бүртгэгдээд мэдээний санд мэдээлэл нь ороогүй 51 нэрийн эм, эмийн түүхий эд, БИБ-ний мэдээллийг нөхөж оруулсан. - Анхдагч, хоёрдогч савлагааны зураггүй 416 нэрийн эм, хэрэглэх зааваргүй 701 нэрийн эм, бар кодгүй 1095 нэрийн эм, зураггүй 170 нэрийн БИБ, хэрэглэх зааваргүй 1347 нэрийн БИБ байсныг холбогдох 162 бүртгүүлэгч байгууллага тус бүрт мэдээлэл ирүүлэх тухай албан бичиг хүргүүлсэн. Үүний дагуу 138 байгууллагын 160(3.8%) нэрийн эмийн анхдагч, хоёрдогч савлагааны зураг, 152(3.6%) эмийн баталгаажсан хэрэглэх заавар, 415 (9.8%) бар код, БИБ-ий 143(9.3%) анхдагч, хоёрдогч савлагааны зураг, БИБ-ий баталгаажсан хэрэглэх заавар 580(37.8%) мэдээллийг ирүүлж тус тус мэдээний санд оруулсан. 2. Эмийн бүртгэлийн “Лайсмед” мэдээний нэгдсэн санд бүртгэгдсэн тусгай зөвшөөрөлтэй үйлдвэр болон ханган нийлүүлэх байгууллагуудын мэдээлэлд үнэлгээ хийж, нэгдсэн дүнг тусгай зөвшөөрлийн комиссын гишүүдэд 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр, 10 дугаар сарын 23 өдрийн ДЗХ-д тус тус танилцуулсан. 2021-2023 онд	100
---------------------------------	--	--	--	---	-----

						шинээр олгосон тусгай зөвшөөрлийн мэдээллийг агентлагийн даргын тушаалтай тулган нэгтгэн гаргасан. 2021 онд шинээр 15, чиглэл нэмсэн 14, 2022 онд шинээр 52, чиглэл нэмсэн 12, 2023 оны 12 сарын 01-ны өдрийн байдлаар шинээр 60, чиглэл нэмсэн 10 байна.	
27.	Арга хэмжээ 3.3 Эм, эмийн түүхий эд, оношлуур, БИБ-ний улсын бүртгэл, сунгалт, өөрчлөлтийн асуудлыг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, бүртгэлийн гэрчилгээ олгоно.	-	Хугацаанд нь бүртгэж шийдвэрлэсэн эм, БИБ, оношлуурын хувь	2022 онд шинэ бүртгэл-712, сунгалт-961, өөрчлөлт-469, хасалт-8 байсан.	Бүртгэлийн үйл ажиллагааг журмын дагуу явуулж, гэрчилгээг олгосон байна.	2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар ХЭЗ-ийн хурал 10 удаа, БОСЗ-ийн хурал 9 удаа, БИБСЗ 10 удаа хуралдаж дараах бүртгэлийн асуудлыг шийдвэрлэсэн. 2023 оны байдлаар 205 бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 205 албан бичиг ирүүлснийг хугацаанд нь шийдвэрлэсэн. Үүнд: Шинэ бүртгэл: 208 1. Импортын эм-208 - Энгийн бүртгэл-92 - Бодлогоор бүртгэх эм-5 - Түргэвчилсэн бүртгэл-111 2. Үндэсний үйлдвэрийн эм-19 3. Эмийн түүхий эд-14 4. Оношлуур- 434 5. Биологийн идэвхт бүтээгдэхүүн-383 Бүртгэлийн хугацаа сунгалт-721 1. Импортын эм-351 2. Импортын уламжлалт эм-11 3. Үндэсний үйлдвэрийн эм -36 4. Үндэсний үйлдвэрийн уламжлалт эм-89 5. Эмийн түүхий эд-14 6. Оношлуур -89 7. Биологийн идэвхт бүтээгдэхүүн -131 Бүртгэлийн өөрчлөлт-499 1. Импортын эм -371 2. Биологийн идэвхт бүтээгдэхүүн-60 3. Оношлуур- 23 4. Үндэсний үйлдвэрийн эмийн өөрчлөлт-14 5. Импортын уламжлалт эм-31 Бүртгэлээс хасалт-58	100

						1. Импортын эм-51 2. Үндэсний үйлдвэрийн эм-5 3. Биологийн идэвхт бүтээгдэхүүн-2	
28.	Арга хэмжээ 3.4 Эм, БИБ-ний бүртгэлийн материалын цахим архив үүсгэнэ.	50 сая (Улсын төсөв)	Цахимд оруулсан архивын баримтын хувь	1994-2021 оны 12000 орчим архивын хөмрөгөөс 2022 онд 3400 буюу 28 хувийг цахим архивт оруулсан.	1994-2021 оны бүртгэлийн архивын хөмрөгөөс 20 хувийг шинээр цахимд оруулсан байна.	1994-2023 онд бүртгэгдсэн 2400 материалын цахим архив үүсгэсэн. Бүртгэлийн архивын хөмрөгөөс 20 хувь цахимд оруулсан.	100
29.	Арга хэмжээ 3.5 Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай, бодлогоор бүртгэх эмийн жагсаалтыг шинэчлэн гаргана.	-	Жагсаалтын төсөлд санал авсан байгууллагын тоо, гарсан саналын тоо, тусгасан саналын тоо	2022 онд шинэчилсэн жагсаалтыг мөрдөн ажиллаж байна.	2023 онд бодлогоор бүртгэх, эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай, эмчилгээний тасалдал үүсдэг эмийн жагсаалтыг шинэчлэн хүний эмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай, 2023 онд бодлогоор бүртгэх эмийн жагсаалтад санал авахаар ЭМЯ-ны орон тооны бус мэргэжлийн 41 салбар зөвлөл, нэгдсэн эмнэлэг, БОЭТ, тусгай эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд 01/495, 01/495 дугаар албан бичиг тус тус хүргүүлж, жагсаалтад тусгах саналыг төрөлжсөн 8 эмнэлэг (УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХӨСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, АӨСҮТ, ЗООНОЗ), 6 мэргэжлийн салбар зөвлөл (Чих хамар, хоолой, Хавдар судлал, Хор судал, Сүрьеэ, Сэтгэц, Цус судлалын мэргэжлийн салбар зөвлөл)-өөс ирүүлсэн саналыг боловсруулж, ХЭЗ-өөс санал авахаар 444 нэрийн эмийн жагсаалтыг нэгтгэж гишүүдэд цахимаар хүргүүлсэн.	70
ДӨРӨВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЛИЦЕНЗИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАЖ АЖИЛЛАНА.							
30.	Арга хэмжээ 4.1 Эм, эмнэлгийн хэрэгсэл, БИБ, оношлуурыг үйлдвэрлэх, импортлох, экспортлох,	-	Хуулийн хугацаанд шийдвэрлэ сэн тусгай зөвшөөрлийн хувь	Зөвшөөрлийн тухай шинэ хууль 2023 оны 01 дүгээр сараас мөрдөгдөж эхэлсэн.	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн тусгай зөвшөөрлийн хувь 90-аас доошгүй байна.	2023 онд тусгай зөвшөөрөл олгох комисс (ТЗОК)-ын хурлыг нийт 14 удаа зохион байгуулж, дараах асуудлыг хэлэлцүүлж, нийт 234 хүсэлтээс 222 буюу 94,8 хувийг шийдвэрлэсэн. Үүнд: - Тусгай зөвшөөрөл шинээр-60 - Чиглэл нэмсэн-10	90

	ханган нийлүүлэх чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулна.					- Тусгай зөвшөөрлийн сунгалт, хаягийн өөрчлөлт бүртгэсэн-31 - Хаягийн өөрчлөлтийн бүртгэл-13 /дангаар / - Тусгай зөвшөөрлийн сунгалт- 68 - Хэсэгчлэн хүчингүй болгосон-4 - Эрх сэргээсэн-3 - Төсөл, ажлын байр дэмжигдээгүй-24 - Түдгэлзүүлсэн-6 - Гэрчилгээ гээгдүүлж дахин олгосон-3	
31.	Арга хэмжээ 4.2 Тусгай зөвшөөрлийн орон тооны бус шинжээчийг журмын дагуу сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулна.	-	Шинээр сонгон шалгаруулсан шинжээчийн тоо	Нийт 33 орон тооны бус шинжээчийг сонгон шалгаруулж, 32 шинжээчтэй гэрээ хийн ажилласан.	Холбогдох журмын дагуу сонгон шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулж, шинжээчдийн тоог нэмэгдүүлсэн байна.	“Тусгай зөвшөөрлийн орон тооны бус шинжээч сонгон шалгаруулах” ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг агентлагийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/13 дугаар тушаалаар батлуулсан. Ажлын хэсэг 2 үе шаттайгаар сонгон шалгаруулалтыг хийж, эхний сонгон шалгаруулалтаар 22 мэргэжилтэн баримт бичгийн бүрдлээр шалгарч, 2-р шатанд 20 мэргэжилтэн мэдлэг сорих шалгалтад тэнцсэн ба тусгай зөвшөөрлийн орон тооны бус шинжээчээр ажиллуулах гэрээ хийсэн. 2021-2022 онд нийт 32 шинжээч ажиллаж байснаас 4 шинжээч тодорхой шалтгааны улмаас шинжээчээр ажиллахаас татгалзсан. 2023 онд 48 шинжээч ажиллаж, өмнөх жилээс 62,5 хувиар шинжээчийн тоог нэмэгдүүлсэн.	90
32.	Арга хэмжээ 4.3 Орон нутагт эм хангамжийн байгууллагын тусгай зөвшөөрөл олгох, сунгах, нэмэлт өөрчлөлт бүртгэлтэй холбоотой ажлын байр нь дээрх хяналт үнэлгээ хийнэ.	30 сая (Улсын төсөв)	Хяналт үнэлгээ хийсэн аймаг, байгууллагын тоо	2022 онд 2 аймагт хяналт үнэлгээ хийсэн.	5 аймагт хяналт үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн байна.	Орон нутагт эм хангамжийн байгууллагын тусгай зөвшөөрөл олгох, сунгах, нэмэлт өөрчлөлт бүртгэлтэй холбоотой ажлын байранд агентлагийн даргын баталсан удирдамжийн дагуу 9 аймгийн нийт 25 байгууллагад хяналт үнэлгээ хийг8 тавигдах шаардлагын дагуу зөвлөмж өгсөн. Үүнд: Дундговь аймгийн “Дундговь эм хангамж” ХХК ханган нийлүүлэх байгууллага; Булган аймгийн Булган эм хангамж ХХК, Ноза ХХК ханган нийлүүлэх байгууллага; Сүхбаатар аймгийн Монос-Сүхбаатар ХХК, МЭИК-ны Сүхбаатар аймаг дахь салбар;	100

						Өвөрхангай аймгийн Азифарм ХХК, МЭИК-ны Өвөрхангай аймаг дах салбар; Дорнод аймгийн "Монос Дорнод" ХХК, "Дорнод эм хангамж" ХХК ханган нийлүүлэх байгууллага; Хэнтий аймгийн Азифарм ХХК, Монос-Хэнтий ХХК, МЭИК-ны Хэнтий аймаг дах салбар; Архангай аймгийн Монос-Архангай ХХК, Монфа трейд ХХК-Архангай салбар, Хангай тун ХХК, МЭИК ХХК-Архангай салбар; Баянхонгор аймгийн МЭИК-ны Баянхонгор аймаг дах салбар, Монос-Баянхонгор ХХК, Мөнхийн тун ХХК-ын салбар, Азифарм ХХК-ны салбар, Наянбулаг Ганга ХХК-д; Завхан аймгийн Монос-Улиастай ХХК, Завхан-Эм хангамж ХХК, Нахиа импекс ХХК-Завхан салбар, Азифарм-Улиастай ХХК-д; Дээрх аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах асуудлыг ТЗОК-ын хурлаар хэлэлцүүлж 100 хувь шийдвэрлүүлсэн.	
33.	Арга хэмжээ 4.4 Аймаг, нийслэлийн тусгай зөвшөөрөл олгох комиссыг эм зүйн мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.	10 сая (Улсын төсөв)	Сургалтад хамрагдсан тусгай зөвшөөрлийн комиссын гишүүдийн хувь	-	Тусгай зөвшөөрлийн комиссын гишүүдэд 2 удаа сургалт явуулж, арга зүйгээр хангасан байна.	ДЭМБ-ын санхүүжилтээр 2023 оны 4 дүгээр сарын 23-наас 4 дүгээр 29-ны өдрүүдэд Хэнтий, Сүхбаатар аймаг, 2023 оны 5 дугаар сарын 10-наас 5 дугаар сарын 13-ны өдрүүдэд Дундговь аймагт орон нутгийн тусгай зөвшөөрөл олгох комисс болон эмийн мэргэжилтэн, эмийн чанарын хяналтын байцаагч, эмч, эм хангамжийн байгууллагын төлөөлөл оролцсон 71 хүнд хууль эрх зүй, хяналт шалгалт, эмийн гаж нөлөө чиглэлээр сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.	100
ТАВ. ЭМИЙН ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАНДАЛТ, СУДАЛГАА ХИЙНЭ.							
34.	Арга хэмжээ 5.1 Монгол Улсын зах зээл дэх эм, эмнэлгийн хэрэгсэл, БИБ-ний чанар, аюулгүй	-	Тандалт, үнэлгээний тоо Тайлан	Эм, эмнэлгийн хэрэгсэл, БИБ-ний чанар, аюулгүй байдлын 6	Нийт 8 удаа тандалт, үнэлгээ хийж, дүнг холбогдах дээд шатны байгууллагад	Зах зээл дэх эм, эмнэлгийн хэрэгсэл, БИБ-ний чанар, аюулгүй байдалд нийт 11 тандалт, үнэлгээ хийсэн. Үүнд: Баримтын үнэлгээ-3 - Архинаас гаргах үйлдэлтэй бүртгэлтэй 4 нэрийн эмэнд баримтын үнэлгээ, цахим орчноор худалдаалагдаж байсан бүртгэлгүй 2 нэрийн эмэнд	100

байдлын тандалт, үнэлгээ хийнэ.		тандалт, 2 үнэлгээ хийсэн.	хүргүүлсэн байна.	тандалт хийж, үр дүнг ДЗХ-д танилцуулж, шийдвэрийг эрүүгийн цагдаагийн албаны эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газарт 01/505 дугаар албан бичгээр хүргүүлсэн. - Уналт таталтын эсрэг эмийн чанар, аюулгүй байдлын тандалт үнэлгээг нийт 121 эмэнд баримтын үнэлгээ хийж, үр дүнг ДЗХ, Хүний эмийн зөвлөлийн хурал (ХЭЗ)-д тус тус хэлэлцүүлж, дахин ХЭЗ-д дахин хэлэлцүүлэхээр болсон. - Himalaya Wellness үйлдвэрлэгчийн улсын бүртгэлд бүртгэлтэй 45 нэрийн эмэнд үнэлгээ хийж, үр дүнг н ДЗХ, ХЭЗ-д тус тус хэлэлцүүлсэн. <u>Зах зээлийн тандалт-8</u> - Геден Рихтер үйлдвэрлэгчийн Гордокс-Апротинин 100000 ОУН эмийн тандалт судалгааны үр дүнг ДЗХ, ЭССЗ-ийн 5-р хурал, ХЭЗ-ийн хурлаар тус тус хэлэлцүүлсэн. - 2023 оны 5 дугаар сарын байдлаар эмийн цахим бүртгэлд байгаа 1540 нэргийн биологийн идэвхт бүтээгдэхүүнд тандалт хийж, үр дүнг ДЗХ-аар хэлэлцүүлсэн. - Эрүүл мэндийн даатгалын сангаас 2022 онд хамгийн их хөнгөлөлт олгосон эхний 10 эмэнд багтсан Зүрх судасны тогтолцоонд нөлөөлөх 5 нэрийн эмэнд эрсдэлд суурилсан зах зээлийн дараах эмийн чанарын төлөвлөгөөт тандалт судалгааг хийж, үр дүнг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. - Эмнэлгийн хэрэгслээс эмнэлгийн бээлийний хэрэглэгчийн тандалт судалгаа 725 эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан хийж, үр дүнг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын хамтралтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авахаар шийдвэрлэв.
--	--	-----------------------------------	--------------------------	---

						- Цахим орчин дахь Д аминдэмийн бодлого зохицуулалт, бүртгэлийн байдалд тандалт судалгаа хийхэд нийт хүн амын 90 гаруй хувь нь дутагдалтай бол ЭМЯ, ХХААХҮЯ-ны бодлого зохицуулалт хангалттай гарсан ч хэрэгжилт хангалтгүй, 14% нь зар сурталчилгааны зөвшөөрөлтэй, 42% нь заавар баталгаажаагүй, Нийтийн сүлжээний 57% нь зөвхөн Д аминдэмийг сурталчилсан байна. - Гедеон рихтерийн 3 нэрийн бүртгэлийн загвараас зөрүүтэй, импортын лицензэд заагдаагүй цувралын эмэнд тандалт хийж, улсын байцаагч нар хууль бус бүртгэлгүй 1 нэрийн тухайн цувралын үлдэгдэл 112 ширхэгийг устгуулах арга хэмжээ авч, 1 хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авсан. - ӨЭМТ-ийн 384 эмч нарын “Эмийн зохистой хэрэглээний мэдлэг, хандлага, дэдлэг үнэлэх” үнэлгээ хийж, үр дүнг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрийн дагуу Өрхийн Анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоонд 01/2046 тоот албан бичгээр чиглэл хүргүүлсэн. - Ханиадны 1 сироп эмэнд холыц илрүүлэх, анхдагч, хоёрдогч савлагааг хуурамч эсэхийг тодорхойлох тандалтыг 3 нэрийн эмэнд хийсэн. Шинжилгээний дүгнэлт гараагүй байна.	
35.	Арга хэмжээ 5.2 Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээж буй эм, эмнэлгийн хэрэгслийн талаарх зар сурталчилгаанд	12 сая (Улсын төсөв)	Тандалт үнэлгээний тоо Тайлан	2022 онд 2 удаа тандалт үнэлгээ хийсэн.	Зар сурталчилгаа 2 удаа тандалт, үнэлгээг хийсэн байна	Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээж буй эм, эмнэлгийн хэрэгслийн талаарх зар сурталчилгаанд 2 тандалт үнэлгээ хийсэн. Үүнд: - ДЭМБ-ийн санхүүжилтээр 2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2023 оны 02 дугаар сарын 28-ний хугацаанд түгээсэн Эм, БИБ-ний зар сурталчилгаанд тандалт үнэлгээ хийсэн. Үүнд: 22 эм, БИБ ханган нийлүүлэх байгууллагын 46 нэрийн эм, БИБ, хүнсний бүтээгдэхүүний ангиаллаар улсын хилээр орж ирдэг	100

	тандалт, үнэлгээ хийнэ.					1 нэрийн бүтээгдэхүүний зар сурталчилгаанд тандалт үнэлгээ хийсэн. 46 нэрийн эм, БИБ-ний зар сурталчилгааны 30 нэрийн эм, БИБ-ний зар сурталчилгаа 65.2% нь зөвшөөрөл авсан байна. 16 нэрийн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний 34.7% зөвшөөрөл аваагүй түгээсэн байсан. - Цахим орчин (facebook) дах хувь хүн, цахим дэлгүүрийн эм, БИБ-ний сүүлийн 1 сарын хугацааны дах зар сурталчилгааны агуулга бүхий нийтлэлүүдэд тандалт хийсэн. Тандалтаар цахим дэлгүүрийн зар сурталчилгаа-4, эм ханган нийлүүлэх байгууллагын цахим хуудасын сурталчилгаа-8, гоо сайханы эмнэлэг-11, уламжлалтийн эмнэлэг-1, эмийн сан-3, хувь хүний зар сурталчилгаа-67 нийт 92 зөвшөөрөлгүй зар сурталчилгаа илэрч давтагдсан тоогоор 74 нэр төрлийн эмийн бүтээгдэхүүнүүд дурьдагдсан байна.Тандалтаар нийт зар сурталчилгааны 82.8% нь бүртгэлгүй эм, БИБ эзэлж, түгээж байгаа зар сурталчилгааны 72.8 хувь иргэдийн нийтэлсэн эмийг албан бус нэршилээр, эмийн зургийг байршуулан сурталчилгааг хийсэн байна. ДЗХ-аар тайлан танилцуулж, тайланг гаалийн ерөнхий газар хүргүүлсэн.	100
36.	Арга хэмжээ 5.3 МУХТЖҮЧ-2.2.7, ЗГҮАХ 2.1.8 Эмийн гаж нөлөө, аюулгүй байдлын мэдээллийг бүртгэж, баталгаажсан тохиолдлыг ОУ-ын вижилайс системд мэдээлсэн байна.	Бүртгэсэн гаж нөлөөний тоо Бүртгэсэн аюулгүй байдлын мэдээллийн тоо ОУ-ын вижилайс системд мэдээлсэн гаж нөлөөний	Бүртгэгдсэн гаж нөлөөний тоо -90 Бүртгэсэн аюулгүй байдлын мэдээлэл-153 ОУ-ын вижилайс системд мэдээлсэн гаж нөлөөний	Эм судлалын салбар зөвлөлийн хурлаар эмийн гаж нөлөө, аюулгүй байдлын мэдээллийг хэлэлцүүлж, баталгаажсан гаж нөлөөг ОУ-ын вижилайс системд	2023 онд бүртгэгдсэн нийт 232 гаж нөлөөний тохиолдол, эмийн аюулгүй байдлын мэдээлэл-694 гадны эм үйлдвэрлэгчээс ирүүлсэн 637 эмийн аюулгүй байдлын мэдээллийг тус бүр хүлээн авч үнэлгээг хийж бүртгэн ЭСС3-ийн 8 удаагийн хурлаар хэлэлцүүлж, баталгаажуулсан. Нийт мэдээллийн тоо өмнөх оноос 53,2 хувиар буюу 1,9 дахин өсч, гаж нөлөөний мэдээлэл дангаараа 2,5 дахин өссөн байна. УППСАЛА төвийн Вижибэйс олон улсын мэдээллийн системээс хүлээн авсан аюулгүй байдлын 1 дохиог ЭСС3-ийн хурлаар хэлэлцүүлэн ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албанд 01/289 дугаар албан бичгээр аюулгүй байдлын хяналтыг хэрэгжүүлэх		

			нөлөөний тохиолдлын тоо	тохиолдлын тоо- 40	мэдээлэх, ОУ- аас аюулгүй байдлын дохио, мэдээлэл хүлээн авч холбогдох байгууллагуу дад мэдээлэл хүргэсэн байна.	тухай мэдээлэл хүргүүлсэн. ЭССЗ-ийн 8 удаагийн хурлаар хэлэлцүүлсэн 232 тохиолдлоос шаардлагатай гэж үзсэн 55 тохиолдлыг 2023 онд илгээснээр нийт 2021-2023 оны хооронд 167 тохиолдлыг MedRa ангиллын дагуу Vigilyze системээр дамжуулан ОУ-д мэдээлсэн.	
37.	Арга хэмжээ 5.4 МУТЖҮЧ-2.2.7, ЗГҮАХ 2.1.8.1 Эмийн гэж нөлөө, аюулгүй байдлын талаар эрүүл мэндийн байгууллага болон олон нийтийн ойлголт хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн аян, мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийнэ.	-	Мэдээлэл, сургалт, сурталчилгааны тоо	Сургалт -3 Сурталчилгаа, постер-15 мэдээлэл-5 тус тус бэлтгэж түгээсэн.	Олон нийт болон эмнэлгийн мэргэжилтэнд зориулсан аян зохион байгуулж, мэдээлэл, сургалт, сурталчилгаа ны тоо өмнөх оноос нэмэгдсэн байна.	Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан Эмийн гэж нөлөөний журмын хэрэгжилтийг хангаж ажиллах тухай 01/449 дугаар албан бичгийг тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймаг нийслэлийн ЭМГ, Амаржих газруудад хүргүүлж, ЭМБ-ын гэж нөлөө, аюулгүй байдлын асуудал хариуцсан мэргэжилтнийг томилон мэдээлэл ирүүлэх ажлын хүрээнд нийт 40 гаруй байгууллагаас хавсралтын дагуу мэдээллийг хүлээн авч хариуцсан мэргэжилтний мэдээний санг үүсгэсэн. Зохион байгуулсан сургалт-3 - 2023 оны 4 дүгээр сарын 23-29-ний өдрүүдэд Сүхбаатар, Хэнтий АЭМГ, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан, эмнэлгийн 40 гаруй мэргэжилтнийг хамруулан “Эмийн гэж нөлөө мэдээлэх тогтолцоо, журмын танилцуулга” сэдвээр 2 удаагийн сургалт хийж, мэргэжилтнүүдэд зөвлөгөө мэдээлэл өгсөн. - 2023 оны 5 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд “Нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн мэргэжилтнүүдэд зориулсан танхимын сургалтад “Эмийн гэж нөлөө үнэлэх, мэдээлэх тогтолцоо, эрх зүйн орчны шинэчлэл, цахим системийн хэрэглээ” сэдвээр 3 удаагийн сургалт хийж, мэдээлэл өгсөн.	100

						Сургалтад Нийслэлийн 9 дүүргийн нийт 500 орчим эм зүйч, жор баригч нар хамрагдсан. - 2023 оны 5 дугаар сарын 8,19,22-ны өдрүүдэд "Нөөц бүртгэх butgel.mohs цахим хуудас, эмийн гаж нөлөө мэдээлэх иРепортинг цахим системийн хэрэглээ болон эмийн чанар, аюулгүй байдалд анхаарах асуудлууд" 2 өдрийн 4 удаагийн цахим сургалт, 1 өдрийн танхимын сургалтад "Эмийн гаж нөлөө мэдээлэх, тогтолцоо, эрх зүйн орчны шинэчлэл, гаж нөлөө мэдээлэх иРепортинг цахим системийн хэрэглээ" сэдвээр сургалт хийсэн. Сургалтад Баруун, Зүүн, Төвийн, Хангайн бүс, Нийслэлийн эрүүл мэндийн газрын харъяа эмнэлгүүдийн нийт 212 эмнэлгийн Эм зүйн албаны дарга болон эм зүйчид хамрагдсан.	
38.	Арга хэмжээ 5.5 Эмийн чанар, аюулгүй байдлын сэрэмжлүүлэг мэдээлэл, эргэн мэдээллийг сайжруулж, эрсдлийг бууруулах хариу арга хэмжээ авна.	Сэрэмжлүүлэг мэдээллийн тоо	2022 онд байгууллага олон нийтэд хүргэсэн сэрэмжлүүлэг мэдээлэл-11	Эмийн чанар, аюулгүй байдалтай холбоотой ирсэн сэрэмжлүүлэг мэдээллийг тухай бүр эрүүл мэндийн байгууллага, олон нийтэд хүргэж, эрсдлийг бууруулах арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.	ДЭМБ-аас ирүүлсэн хуурамч, стандартын бус эмийн 8 сэрэмжлүүлэг, эмийн аюулгүй байдал, зах зээлээс эргүүлэн татсан 2 эмийн мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, эрсдлээс сэргийлж, ГЕГ-ын хяналт шалгалтын газарт 3 удаа албан бичиг хүргүүлж дараах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Үүнд: -Хуурамч, стандартын бус эмээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэл бүхий импортын сироп эм болон туслах бодисын чанар аюулгүй байдлыг тандахаар 10 ЭХНБ, 3 эмийн үйлдвэрт албан бичиг хүргүүлж, 2 эмийн үйлдвэрээс дотоод хяналтын шаардлага хангасан үр дүн хүлээн авсан. -Сироп эмэнд хольцын туршилт шинжилгээ хийлгэхээр 01/1951 дугаар албан бичиг ШШЕГ-т хүргүүлсэн. Зах зээл дэх бүртгэлгүй, бүртгэлийн загвараас зөрүүтэй хуурамч байх магадлалтай эмийн мэдээллийг ирүүлэх тухай 01/1031 дугаар албан бичгийг МЭБНЭХ, МЭХБХ, ЭЗМТХ-нд хүргүүлсэн. -Эмийн гаж нөлөө, аюулгүй байдлын шаардлагатай гэж үзсэн сэрэмжлүүлгийг ЭССЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, 60 ЭМБ-дад хүргүүлсэн.	100	

									-Гаж нөлөө, аюулгүй байдал илэрсэн 1 эмийг лабораторийн шинжилгээнд хамруулж дүгнэлт гаргуулсан. 2 тан эмэнд хэрэглэх зааврын гаж нөлөөний хэсэгт өөрчлөлт оруулсан, 1 тарилгын эмтэй холбоотой бүртгэгдсэн гаж нөлөөнд тарилгын уусмалын үйлдвэрлэлийн зогсоосон. Гаж гөлөө илэрсэн 1 эмийн хэрэглэх заавраас нэг заалтыг хасуулсан.
39.	Арга хэмжээ 5.6 МҮХТЖУЧ 7.3.2, ЗГҮАХ 4.3.4.2 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2022 оны төлөвлөгөөний 6 арга хэмжээг 100 хувь хэрэгжүүлсэн.	Төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагад хамааралтай арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж Үндэсний хороонд тайлагнасан байна.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх” Үндэсний хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд агентлагийн даргын 01/158 дугаар албан бичгээр саналыг хүргүүлсэн. Төлөвлөгөөг Хууль зүй дотоод хэргийн сайд бөгөөд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооны дарга 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр баталсан. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт 100 хувь. Төлөвлөгөөний биелэлтийг хагас жил, жилийн эцсээр гаргаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүлсэн.	100			
ЗУРГАА. ЭМ ЗҮЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БИЕ ДААСАН ХЯНАЛТЫГ ТӨЛӨВШҮҮЛНЭ.									
40.	Арга хэмжээ 6.1 Улсын хэмжээнд нийтийн үйлчилгээтэй эмийн сан, эрүүл мэндийн байгууллагын хяналт шалгалтад хамруулж, төлөвлөгөөт хяналт шалгалт хийнэ.	Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо Арилгасан зөрчлийн хувь	Нийт хяналт шалгалтад 613 байгууллага хамрагдсан.	Төлөвлөсөн байгууллагад хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлын дагуу арга авч хэмжээ авч тайланг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлнэ.	ЭМЯ-ны СХГ-ын даргын баталсан 2023 оны “Эмийн үйлдвэр, эм хангамжийн байгууллагуудын үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” 10-00/19 дугаартай удирдамжийн хүрээнд аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж буй нийт 366 эмийн сан, 4 эм ханган нийлүүлэх байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, 10.16.1 кодтой “Эмийн сангийн үйл ажиллагааг шалгах”, 10.16.2 кодтой “Эм, эмнэлгийн хэрэгсэл, БИБ-ний хадгалалт, түгээлтийг шалгах” хяналтын хуудсуудаар үнэлэхэд 218 байгууллага бага, 127 байгууллага дунд, 21 байгууллага их эрсдэлтэй тус тус үнэлэгдсэн ба шалгалтаар илэрсэн дутагдлуудыг арилгуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар 2204 заалт	100			

						бүхий 235 албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, биелэлтийг хангуулан ажиллаж байна. Хяналт шалгалтын явцад 9 байгууллагад илэрсэн хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан, Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, бүртгэлийн загвараас зөрүүтэй, хадгалалтын горим алдагдсан нийт 119 нэрийн 3130 ширхэг 2360710 төгрөгийн үнэ бүхий эм, бүтээгдэхүүнийг Засгийн Газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хүрээнд байгууллагын дотоод хяналтын журмыг үндэслэн устгуулж, эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлж ажилласан. Зөрчлийн тухай хуулийн хүрээнд 48 нэрийн 1805 ширхэг 2024100 төгрөгийн зөрчилтэй бүтээгдэхүүнийг шийдвэрлүүлэхээр орон тооны бус устгалын комисст шилжүүлж, 2 иргэн, 18 ААН-д 10.3 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, бүрэн барагдуулсан. ЭМЯ-ны СХГ, БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газрын дарга нарын хамтран баталсан "Эмнэлгүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай" 10-00/17 дугаартай удирдамжийн хүрээнд 3Г-ын 2023 оны 79 дүгээр тогтоолоор баталсан Хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр хамтарсан 193, дангаар 12 аймгийн 73 эрүүл мэндийн байгууллагад хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс хамтарсан 186 байгууллага, дангаар 64 эрүүл мэндийн байгууллага буюу нийт төлөвлөсөн объектын 95,7 хувийг хамруулсан. Шалгалтад хамрагдсан эрүүл мэндийн байгууллагуудыг 10.17.1 кодтой "Эрүүл мэндийн байгууллагын эм зүйн тусламж үйлчилгээг шалгах" хяналтын хуудсаар үнэлэхэд хамрагдсан 250 байгууллагын 109 буюу 43,6 хувь бага, 112 буюу 44,8 хувь дунд, 29 буюу 11,6 хувь их эрсдэлтэй үнэлэгдсэн. Улсын байцаагчийн хяналт шалгалтаар арга хэмжээ авах эрх үүсээгүй, прокурорын харьяалал тогтоогдоогүй хүртэлх хугацаанд хийгдсэн
--	--	--	--	--	--	---

						төлөвлөгөөт хяналт шалгалтын үед илэрсэн хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан, хаяг шошгын зөрчилтэй 391 нэрийн 10790 ширхэг, 21438850 төгрөгийн үнэ бүхий эм, бүтээгдэхүүнийг Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хүрээнд байгууллагын дотоод хяналтын журмыг үндэслэн дотоод хяналтын багаар устуулах арга хэмжээ авч, эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлж ажиллалаа. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар хамтарсан шалгалтаар 1696 заалт бүхий 141 улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлага, дангаар 841 заалт бүхий 45 улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлага хүргүүлж, зөрчил гаргасан 5 байгууллага, 4 албан тушаалтанд 9.0 сая төгрөгийн шийтгэвэр ногдуулан барагдуулж, Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, бүртгэлийн загвараас зөрүүтэй, хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан, чанарын шаардлага хангахгүй 72 нэрийн 6823 ширхэг 8120262 төгрөгийн эм бэлдмэлийг хурааж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн. Хяналт шалгалтын нэгдсэн дүнг 01/1859 дугаар албан бичгээр ЭМЯ-ны СХГ-т хүргүүлсэн.	
41.	Арга хэмжээ 6.2 Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний өргөдөл, хүсэлтээр болон хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулсан тохиолдолд	80 сая (Улсын төсөв)	Хийсэн хяналт шалгалтын тоо Арилгасан зөрчлийн тоо	Нийт 38 өргөдөл, 149 албан бичгийн дагуу 81 байгууллагад хяналт шалгалт хийсэн. Нийт 88 байгууллагын зөрчлийг арилгуулж, 133 зөрчилд 34 заалттай 8 албан шаардлага, 99 заалттай 13	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу хяналт шалгалтыг хийж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ тухай бүрт авч	Тайлангийн хугацаанд нийт 268 албан бичиг /хариутай 212, хариугүй 56/, 59 өргөдөл, гомдол хүлээн авч, 207 байгууллагад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлын дагуу 55 албан бичгээр хариу хүргүүлсэн байна. Шийдвэрлэх шатандаа 4 албан бичиг байна. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд Зөрчил шалган шийдвэрлэх хуулийн дагуу зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, 15 хэрэг материалыг хялбаршуулсан журмаар, 2 зөрчлийн хэрэг нээн шийдвэрлэж,	100

	телевөгөөт бус хяналт шалгалт хийнэ.			зөвлөмж, албан бичиг хүргүүлсэн.	60	хэрэгжүүлсэн байна.	Зөрчлийн тухай хуулийн 6.6 дугаар зүйлийн холбогдох заалтыг үндэслэн 13 байгууллагад 13,5 сая, 3 албан тушаалтанд 450,0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч барагдуулан, зөрчил үйлдэж олсон мөнгөн орлого болох 18785190 төгрөгийн хууль бус орлогыг улсын төсөвт төвлөрүүлж, Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй болон бүртгэлийн загвараас зөрүүтэй 9 нэрийн 234 ширхэг 2891067 төгрөгийн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн.	
42.	Арга хэмжээ 6.3 Сонгогдсон дотоодын үйлдвэрийн үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийнэ.	5.5 сая (Улсын төсөв)	Хамрагдсан байгууллагын тоо Тайлан	2022 онд дотоодын үйлдвэрийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийсэн.		Сонгогдсон дотоодын үйлдвэрийн үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийж, үнэлгээний зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран баталсан 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 20/A/95 дугаартай удирдамжийн хүрээнд дотоодын 41 эмийн үйлдвэрээс 19 эмийн үйлдвэрийг сонгон хамтарсан хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгч ажилласан. ЭЭХХЗГ-ын даргын 2021 оны A/168 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу 15 үндсэн шалгуур үзүүлэлтээр 13 эмийн үйлдвэрт хяналт, үнэлгээ хийхэд "Эм үйлдвэрлэлийн зохистой дадал" (GMP)-ын хэрэгжилт 63.6%-тай байна.	100
43.	Арга хэмжээ 6.4 Зах зээлд худалдаалагдаж буй хуурамч, улсын бүртгэлд бүртгэгдээгүй, бүртгэлийн загвараас зөрүүтэй, чанар, стандартын шаардлага хангаагүй эм, эмнэлгийн хэрэгсэл, БИБ,	-	Арилгасан зөрчлийн тоо	2022 онд 11 байгууллагын нийт 226 нэрийн 2885 ширхэг 183.084.794 төгрөгийн эмийг устгуулж, 2 нэрийн эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг буцаан татан авалт хийлгүүлсэн.		Эрүүл мэндийн 600 байгууллагад зах зээлд худалдаалаг даж байгаа чанарын шаардлага хангахгүй, улсын бүртгэлд бүртгэгдээгүй эмийг илрүүлж, зөрчлийг бүрэн	Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран баталсан 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 20/A/95 дугаартай удирдамжийн хүрээнд 357 байгууллагад хамтарсан хяналт шалгалт, үнэлгээний явцад 10 эмийн санд худалдаж байсан 61 нэрийн 1698ш, 3223323 төгрөгийн хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан, хаяг шошгын зөрчилтэй, Монгол улсын эмийн бүртгэлийн загвараас зөрүүтэй эм, эмнэлгийн хэрэгслийг илрүүлж, устгуулах арга хэмжээ авч, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллалаа. Мөн тус удирдамжийн хүрээнд зориулалтын бус газар худалдааны төв, Америк барааны дэлгүүрт худалдаалагдаж байгаа эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгсэлд тандалт үнэлгээ	100

	худалдаалагдахаа с урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ.				арилгасан байна.	хийж худалдагчаас асуумж авч мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. "Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" 07/18 дугаартай удирдамжийн хүрээнд 228 эмийн сан, 132 эмнэлэг, 51 ЭХНБ, нийт 412 байгууллагад хяналт шалгалт хийж, 8 байгууллагад зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулан, 6 байгууллага, 2 иргэнд 7650.000 төгрөгийн торгууль, 13126900 төгрөгийн нөхөн төлбөрийг барагдуулан, 16 нэрийн 1170 ширхэг 3499617 төгрөгийн зөрчилтэй бүтээгдэхүүнийг орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн.	
44.	Арга хэмжээ 6.5 Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана.	Хяналт тавьсан байгууллагын хувь	Хяналт тавьсан байгууллагын тоо-195	Тусгай зөвшөөрөл авснаас хойш 6 сараас дээш хугацаанд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуу дыг бүрэн хамруулсан байна.	ЭЗХХЗГ-ын ТЗОК-ийн хурлаас 2022 онд тусгай зөвшөөрөл шинээр олгосон болон чиглэл нэмсэн 64 байгууллагын мэдээллийг гаргасан. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын баталсан 01/15 дугаар "Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага болон эмийн үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх тухай" удирдамжийн хүрээнд тусгай зөвшөөрлийг шинээр олгосон 5, чиглэл нэмсэн 7, нэмэлт өөрчлөлт оруулсан 2, хаягийн өөрчлөлт хийгдсэн 1, нийт 15 эм хангамжийн байгууллагад явцын хяналт хийснээс 14 нь тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг биелүүлж, 1 /Шинжьюку ХХК/ эм хангамжийн байгууллага үйл ажиллагаа явуулаагүй байсан.	100	
ДОЛОО. ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛНА.							
45.	Арга хэмжээ 7.1 "Алсын хараа-2050" 2.2.26, ЗГҮАХ 2.1.8. Эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжид	Шалгалт тохируулга хийсэн тоног төхөөрөмжийн тоо	2022 онд 1624 тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийсэн.	Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа 1000 эмнэлгийн тоног төхөөрөмжийг	Төрийн өмчийн эрүүл мэнд байгууллагаас шалгалт тохируулга хийлгэх хэрэгцээ шаардлагын судалгаа авч "ЭМБ-д ашиглагдаж эмнэлгийн тоног төхөөрөмжид 2023 онд шалгалт тохируулга хийх хуваарь"-ийг боловсруулж, агентлагийн даргаар батлуулсан. ЭМЯ-ны харьяа 2, НЭМГ-ын харьяа 6, орон нутгийн 34, хувийн хэвшлийн 127 нийт 169 ЭМБ-ын 1912 эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийснээс 88.39 хувь тэнцсэн. Нийт 169 ЭМБ-тай шалгалт тохируулгын гэрээ байгуулсан. Мөн шалгалт	100	

шалгалт тохируулга хийнэ.	шалгалт тохируулгад хамруулна.	шалгалт тохируулгад хамруулна.	Олон улсын хэмжил зүйн байгууллага АНУ-ын “Флюке Биомедикал” ХХК-д 24 анализатор, симуляторд шалгалт тохируулга хийлгэх хүсэлтийг цахимаар илгээсэн. Тус газраас Монгол улс дах албан ёсны дистрибьютерээр дамжуулан тус ажлыг гүйцэтгүүлэх шаардлагатай гэсэн хариу ирж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендерийг 2 удаа зохион байгуулж, хамгийн сайн үнэлэгдсэн “Интер Сайнс” ХХК-тай ЭЭХХЗГ/03/34 дүгээр “Хэмжилтийн тоног төхөөрөмжийн баталгаажуулалт хийлгэх гэрээ”-г байгуулж, “Флюке Биомедикал” компани руу 14 нэр төрлийн 25 анализатор, симуляторыг илгээж, 2023 оны 11 дүгээр 22-ноос 12 дугаар сарын 05-ны өдрүүдэд баталгаажуулалт хийлгэсэн.	100
46. Арга хэмжээ 7.2 “Алсын хараа-2050” 2.2.26, ЗГҮАХ 2.1.8. Шалгалт тохируулгын симулятор, анализаторыг олон улсын хэмжил зүйн байгууллагаар баталгаажуулалт хийлгэнэ.	Баталгаажуулалт хийгдсэн симулятор, анализаторын хувь	2022 онд олон улсын хэмжил зүйн байгууллагаар симулятор, анализаторыг 100 хувь баталгаажуулсан.	Олон улсын хэмжил зүйн байгууллага АНУ-ын “Флюке Биомедикал” ХХК-д 24 анализатор, симуляторд шалгалт тохируулга хийлгэх хүсэлтийг цахимаар илгээсэн. Тус газраас Монгол улс дах албан ёсны дистрибьютерээр дамжуулан тус ажлыг гүйцэтгүүлэх шаардлагатай гэсэн хариу ирж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендерийг 2 удаа зохион байгуулж, хамгийн сайн үнэлэгдсэн “Интер Сайнс” ХХК-тай ЭЭХХЗГ/03/34 дүгээр “Хэмжилтийн тоног төхөөрөмжийн баталгаажуулалт хийлгэх гэрээ”-г байгуулж, “Флюке Биомедикал” компани руу 14 нэр төрлийн 25 анализатор, симуляторыг илгээж, 2023 оны 11 дүгээр 22-ноос 12 дугаар сарын 05-ны өдрүүдэд баталгаажуулалт хийлгэсэн. <td>100</td>	100
47. Арга хэмжээ 7.3 “Алсын хараа-2050” 2.2.26, ЗГҮАХ 2.1.8 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сангийн ашиглалтад үнэлгээ хийнэ.	Үнэлгээнд хамрагдсан байгууллагын тоо	-	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сангийн ашиглалтад үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж, үнэлгээ хийх хуваарийг боловсруулж, агентлагийн даргын А/57 дугаар тушаалаар батлуулсан. ЭМЯ-ны харьяа 19, НЭМГ-ын харьяа 21 буюу нийт 40 эрүүл мэндийн байгууллагад “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сан”-д бүртгэлтэй эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээлэлд үндэслэн үнэлгээг хийж, тайланд үндэслэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөсөн. <td>90</td>	90

48.	Арга хэмжээ 7.4 “Эрүүл мэндийн технологи-2023” цахим сэтгүүл гаргана.	-	Цахим сэтгүүлийн хандалтын тоо	“Эрүүл мэндийн технологи-2023” цахим сэтгүүл гаргасан.	“Эрүүл мэндийн технологи- 2023” цахим сэтгүүлийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна.	Сүүлийн 5 жилд эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийсэн мэдээлэл, шалгалт тохируулгын 2023 оны нэгтгэл, Төрийн өмчийн ЭМБ-ын хүчилтөрөгчийн хэрэгцээний үнэлгээний тайлан, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сангийн тайлан, Шалгалт тохируулгын дараах засварын үйлчилгээний судалгааны тайлан, Эрүүл мэндийн салбарт нэвтрүүлсэн шинэ дэвшилтэт техник, технологийн судалгааны тайлан, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер бэлтгэдэг сургуулиудаас төгсөн гарч буй техникийн ухааны магистр, докторын өгүүлэл, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд нэвтэрсэн дэвшилтэт эмнэлгийн тоног төхөөрөмж, үйл ажиллагаанд шинээр нэвтрүүлсэн технологи бүхий мэдээллийг агуулсан 4 бүлэг 60 нүүр сэтгүүлийн эх бэлтгэж, цахим сэтгүүл гаргасан. Хандалтын тоо-98	100
49.	Арга хэмжээ 7.5 Хүчилтөрөгчийн үйлдвэр, хийн хангамж хариуцсан хүний нөөцийг чадавхжуулах сургалт зохион байгуулна.	65 сая (Улсын төсөв ОУБ)	Сургалтад хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо	2022 онд 22 эрүүл мэндийн байгууллагын 22 хүний сургалтад хамрагдсан.	Нийт 24 эрүүл мэндийн байгууллагын хүчилтөрөгчийн үйлдвэр, хийн хангамж хариуцсан хүний нөөцийг сургалтад хамруулсан байна.	Хүчилтөрөгчийн үйлдвэр, хийн хангамж хариуцсан хүний нөөцийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах хүчилтөрөгчийн нийлүүлэх байгууллага болон даралтад савны ашиглалт, аюулгүй ажиллагааны сургагч эрхлэгч байгууллагуудтай холбогдон мэдээлэл авч, сургалтын удирдамж, хөтөлбөрийг боловсруулсан. Хүчилтөрөгчийн үйлдвэр, хийн хангамж чиглэлээр багшлах боловсон хүчин дутмаг, сургалт зохион байгуулах санхүүжилт байхгүй тул тус сургалтыг зохион байгуулах боломжгүй байсан.	30
50.	Арга хэмжээ 7.6 Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын хүчилтөрөгчийн хэрэгцээний үнэлгээ хийнэ.	-	Үнэлгээний тайлан	2022 онд төрийн өмчийн ЭМБ-ын хүчилтөрөгчийн хангамж, үйлдвэрийн өнөөгийн байдалд үнэлгээ хийсэн.	Төрийн өмчийн ЭМБ-ын хүчилтөрөгчийн хэрэгцээнд үнэлгээ хийж, тайланг холбогдох дээд шатны байгууллагад	Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын хүчилтөрөгчийн хэрэгцээнд үнэлгээ хийх асуумж, удирдамжийг агентлагийн даргаар батлуулж, 01/343 дугаар албан бичгээр асуумжийг ЭМБ-д хүргүүлсэн. ЭМЯ-ны харьяа 11, НЭМГ-ын харьяа 12, орон нутгийн харьяа 17 буюу нийт 40 эрүүл мэндийн байгууллагаас ирсэн мэдээллийг нэгтгэж, тайланг А/498 дугаар албан бичгээр ЭМЯ-нд хүргүүлсэн.	100

						хүргүүлсэн байна.				
51.	Арга хэмжээ 7.7 Эрүүл мэндийн салбарт нийлүүлэгдэж буй эмнэлгийн тоног төхөөрөмжид хяналт тавиж, “Урьдчилсан дүгнэлт” гаргана.	-	Урьдчилсан дүгнэлт гаргуулах албан хүсэлтийн шийдвэрлэл тийн хувь	Урьдчилсан дүгнэлт гаргуулах албан хүсэлтийн шийдвэрлэл тийг 98 хувь хэрэгжүүлсэн.	Урьдчилсан дүгнэлт гаргуулах албан хүсэлтийг дагуу техникийн комисс ажиллаж, 95 хувиас дээш шийдвэрлэсэн байна.	Ханган нийлүүлэх 28 байгууллагын 93 хүсэлтийн дагуу захиалагч байгууллагатай хийсэн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, тоног төхөөрөмжийн холбогдох баримт бичигт үндэслэн 868 (давхардсан тоогоор) нэр төрлийн 3100 эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн марк модель, техникийн үзүүлэлт, бүрэн бүтэн байдлыг хангаж буй эсэхийг шалгаж, нийт 93 техникийн комиссын урьдчилсан дүгнэлт гарган холбогдох байгууллагад хүргүүлсэн. Урьдчилсан дүгнэлт гаргуулах хүсэлтийн дагуу техникийн комиссын бүрэлдэхүүн ажиллаж, хүсэлтийг 100 хувь шийдвэрлэсэн.	100			
НАЙМ. ЭМ ШИНЖЛЭХ ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛНА.										
52.	Арга хэмжээ 8.1 Хууль хяналтын байгууллага, аж ахуйн нэгж, улсын байцаагчийн ирүүлсэн дээжид үндэсний болон олон улсын арга, аргачлалыг ашиглан шинжилгээг хийнэ.	300 сая (Улсын төсөв)	Шинжилгээнд хамрагдсан дээжийн тоо	1957 дээжид шинжилгээ хийж, хариуг олгосон.	1900-аас дээш дээжид шинжилгээ хийсэн байна.	Дээжийн талаар: 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар 22 нэр, төрлийн нийт 2535 дээжийг 27122 үзүүлэлтээр шинжилгээнд оруулснаас импортын 720, дотоодын 1815 дээж хамрагдсан байна. Үүнээс: Шинжилгээ хийлгэх хүсэлтээр: - Сунгалт, хяналтын албан бичгээр ирүүлсэн дээж-1538. Үүнээс хордлого гомдол 11 дээж (тарилгын нунтаг 3, эмнэлгийн жижиг хэрэгсэл 8) - Байцаагчаас ирүүлсэн дээж-52. Үүнээс гомдол 7 дээж - Шинэ бүртгэлийн дээж-683. Үүнээс БИБ дээж-492 - Тандалт судалгаа хийх дээж-188, үүнээс ХӨСҮТ-ээс ирүүлсэн дээж-181, тандалт судалгааны газраас ирүүлсэн дээж-7 - Цагдаагаас ирүүлсэн дээж-13 - АТГ-ээс ирүүлсэн дээж-50 - Гомдлоор ирүүлсэн дээж-11	100			
53.	Арга хэмжээ 8.2	-	Шинээр суурилуулсан	2022 онд нийт ашиглагдаж буй	Шинээр суурилуулсан	Эм шинжлэх лабораторийн үйл ажиллагаанд 9 багаж, лабораторийн туслах хэрэгсэл шинээр худалдан авч,	100			

	Эм шинжлэх лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулна.	тоног төхөөрөмжөөр хийсэн шинжилгээний тоо	багаж тоног төхөөрөмжийн нэр төрөл-110	тоног төхөөрөмжийг тогтмол ашигладаг болсон байна.	5 багаж, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн захиалгааар ашиглалтанд оруулсан. Үүнд: - Механик полириметр-54 дээж - Термостат-302 дээж - Автоклав-1232 дээж - Цахилгаан голцоо шатаагч-516 дээж - Лабораторийн хөргөгч - Өндөр идэвхит хроматографийн багана Багаж, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн захиалгаар - ААС-ын редукторыг захиалан сольсон. - Бат бөх тодорхойлох багажны мотор, жийрэг (1 сая) худалдан авч багажийг хэвийн ажиллагаанд оруулж, 115 дээж шинжилсэн. - Гурван ус нэрэгч аппаратыг шүүлтүүрийг худалдан авч нийт 12 шүүлтүүр солиулсан. 502 тоот ерөөний ус нэрэгч аппаратын моторт алдаа гарч ажиллахгүй байсныг засуулж, хэвийн ажиллагаатай болгосон. - Гурван ус нэрэгч аппаратын хоолой, холболтын хэсгийг бүрэн сольсон. - Хоёр өндөр идэвхит шингэний хроматографийн багажны жийргэвчийг сольсон.	
54.	Арга хэмжээ 8.3 "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага" MNS/ISO IES 17025-2018 стандартын хүрээнд итгэмжлэлийн	3 сая (Улсын төсөв)	Сунгуулсан MNS/ISO IES 17025-2018 итгэмжлэлийн гэрчилгээ	MNS/ISO IES 17025 -2018 итгэмжлэлийн гэрчилгээг сунгуулсан байна.	Үндэсний итгэмжлэлийн төвийн A/76 дугаар тушаалаар итгэмжлэлийн газрын давтан үнэлгээнд амжилттай хамрагдаж, MNS/ISO IES 17025-2018 итгэмжлэлийн гэрчилгээгээ 4 жилээр сунгуулсан.	90

	гэрчилгээг сунгуулна.							1. БНСУ-д зохион байгуулагдсан "Вакцины цуврал чөлөөлөх 6 дугаар уулзалт"-д эм шинжлэх лабораторийн 3 мэргэжилтнийг ДЭМБ-ын санхүүжилтээр хамруулсан. 2. "Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын үндэсний тогтолцоог сайжруулах болон жишиг үнэлгээ хийх" ажлын хэсгийн хурлаар хатуу зохицуулалттай орнуудаас ирж буй вакциныг бодлогын түвшинд бүртгэх, "Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль"-д вакцины зохицуулалт, вакцины бичиг баримтын хяналт, бүртгэл, эрсдэлийг тооцон шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээнд хамруулах талаар зөвлөсөн.	50
55.	Арга хэмжээ 8.5 Вакцины цуврал чөлөөлөх бэлтгэл ажлыг хангана.	20 сая (Улсын төсөв)	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	2022 онд хүний нөөцөө гадаад сургалтад хамруулсан.	Төлөвлөсөн арга хэмжээний бэлтгэл хангагдсан байна.	ЕС. ЭМ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОХИСТОЙ ДАДАЛ (GMP)-ЫН ШААРДЛАГЫГ ХАНГАСАН ЭМИЙН ҮЙЛДВЭРИЙН ТООГ ҮЕ ШАТТАЙГААР НЭМЭГДҮҮЛНЭ.			
56.	Арга хэмжээ 9.1 "Эм үйлдвэрлэлийн зохиистой дадал" (GMP)-ын батламж олгох үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулна.	-	Шинээр батламж авсан үйлдвэрийн тоо	2022 онд батламж авсан үйлдвэр-2 (уламжлал эмийн үйлдвэр-1)	Хүний эмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батламж олгосон үйлдвэрийн тоо нэмэгдсэн байна.	Үндэсний эмийн үйлдвэрүүдэд "Эм үйлдвэрлэлийн зохиистой дадал"-ыг нэвтрүүлэх ажлын хүрээнд: 2023 онд GMP-ийн батламжийг сунгах, чиглэл нэмэх үйлдвэрүүдийн тайлан үнэлгээний дүнг ХЭЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6.2.5, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2021 оны А/168 дугаар тушаалаар батлагдсан "GMP батламж олгох журам"-ын 2.2.8 дах заалт, "Эм үйлдвэрлэлийн зохиистой дадал" (GMP)-ын шинжээчийн багийн дүгнэлтийг тус тус үндэслэн 100 хувийн саналаар "Мөнхийн тун" ХХК-ийн Тунфарм эмийн үйлдвэрийн "Эм үйлдвэрлэлийн зохиистой дадал" (GMP)-ын батламжийн хугацааг сунгах, "Монос фарм" ХХК-ийн эмийн үйлдвэрийн хатуу тугнагдсан эмийн "Эм үйлдвэрлэлийн зохиистой дадал" (GMP)-ын батламжийн хугацааг сунгах, GMP-ийн батламжид "шингэн болон зөөлөн" эмийн хэлбэрийг нэмэлтээр оруулахыг дэмжсэн. Батламжийг			100

							агентлагийн даргын А/64 дүгээр тушаалаар сунгаж, батламжийг гардуулсан. Улсын 2-р төв эмнэлгийн Цөмийн оношилгоо эмчилгээний төвийн Цацраг идэвхит эмийн үйлдвэр 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдөр "Эм үйлдвэрлэлийн зохистой дадал" (GMP)-ын батламж авах хүсэлт ирүүлсэн ба үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулан ажиллаж байна.			
57.	Арга хэмжээ 9.2 Үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүлэл шинээр батлах, хугацаа сунгах, өөрчлөлт оруулах үйл ажиллагааг зохион байгуулна.	11 сая (Улсын төсөв)	Батлагдсан фармакопейн өгүүлэлийн тоо	2022 онд үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүлэл батлагдсан.	25	Фармакопейн хорооны хурлаар үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүлэл хэлэлцүүлж, батлуулсан байна.	Фармакопейн хороо 2023 онд 2 удаа хурал зохион байгуулж, үндэсний үйлдвэрлэлийн шинээр батлуулах 4 нэрийн эмийн үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүллийн төслийг баталж, 13 нэрийн эмийн үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүллийг сунгаж, уламжлалт эмийн фармакопейн өгүүлэлд санал, зөвлөмж өгсөн.	100		
58.	Арга хэмжээ 9.3 Хүний эмийн зөвлөлийн эм зүйн салбар зөвлөлийн хурлыг зохион байгуулна.	4.5 сая (Улсын төсөв)	Гарсан шийдвэрийн тоо	2022 онд хүний эмийн зөвлөлийн хурлаар үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүлэл, стандарт хэлэлцүүлсэн.	14	Хүний эмийн зөвлөлийн үйл ажиллагаа хууль журмын дагуу явагдсан байна.	Эм зүйн салбар зөвлөлийн хурлыг 3 удаа зохион байгуулж, шинээр батлуулах 8 байгууллагын үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүлэл, 3 байгууллагын шинээр батлуулах 3 стандартын төсөл, өөрчлөлт оруулах 1 стандартын төслийг шийдвэрлэсэн. Үүнд: - Дэмжигдсэн ҮӨӨ-10 - Дэмжигдсэн стандартын төсөл-2 - Өөрчлөлт оруулсан ҮӨӨ-1	100		
АРАВ. ЭМ ХАНГАМЖИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.										
59.	Арга хэмжээ 10.1 Төрийн өмчийн ЭМБ-ын 2022 онд худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслийн тайланг авч	-	Дүн шинжилгээ бүхий тайлан	Төрийн өмчийн ЭМБ-ын 2019-2021 онд худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслийн үнэлгээний		Тайлан нэгтгэж, холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.	Төрийн өмчийн ЭМБ-ын 2022 онд худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, төрөөс эмийн зардлыг нь хариуцан амбулаториор эмчлэх эмийн тайлан мэдээг ирүүлэх тухай 01/247 дугаар албан бичгийг ЭМБ-д хүргүүлсэн. Аймаг, нийслэлийн төрийн өмчийн 43 ЭМБ-ын тайланг хүлээн авч нэгтгэсэн. Эрүүл мэндийн салбарт 2022 онд "Төрийн болон орон	90		

